



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Нийслэл, дүүргийн бодлого, зорилт түүний хэрэгжилтийн явц, үр дүнг дүүргийн иргэд, олон нийтэд түгээн таниулах, бодлого, төлөвлөлтийн баримт бичигт иргэдийн санал, санаачилгыг хүлээн авч, тусгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бямбагэрэл

Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурал дахь Монгол ардын
намын бүлгийн дарга,
Зөвлөлийн гишүүн,
Төлөөлөгч

Гишүүд:

Б.Болортунгалаг

Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, Хүний
эрх, ёс зүй, өргөдлийн
хорооны дарга

Н.Доржпүрэв

Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч,
Үйлдвэрлэл үйлчилгээ,
хөдөлмөр эрхлэлтийг
дэмжих хорооны дарга

Б.Ерөө

Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, Эрх зүй,
нутгийн удирдлагын
хөгжлийн хорооны гишүүн

Б.Нямдорж

Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, Төсөв

санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны гишүүн

Н.Сайнболд

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Төсвийн зарцуулалтын хяналтын хорооны дарга

Д.Уянга

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны гишүүн

Э.Уянга

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Ногоон хөгжил, газрын харилцааны хорооны гишүүн

С.Уянгазул

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн хорооны гишүүн

Нарийн бичиг:

Б.Нацагдорж

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга

2.Ажлын хэсгээс зохион байгуулах ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг тухай бүрд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Бямбагэрэл)-т даалгасугай.

3.Ажлын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР

